

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/17/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 260512 Цахим хаяг: tsogbayar.a@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 260512 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	19
3.5.3 Нэмэлт төсөв	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	23
4.5.1 Завсрын аудитын талаар.....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт.....	26
5.2 Албан шаардлага	27
5.3 Зөвлөмж	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний
ТӨОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд



АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/422
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 249,888.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үйлчлүүлэгчдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 122,799.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, тооцоог бодож баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 35,699.3 мянган төгрөгийн шатахууныг шууд худалдан авсан;
- Ээлжийн ажилтнуудад асруулагчдын хоолны ор хоногийн зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлтийн нийт 35,280.0 мянган төгрөгийг илүү олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 45 дугаар зүйлийн 45.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.4, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 44 дүгээр зүйлийн 44.1, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/130 дугаар тушаалын заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг", нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Ахмад настны үндэсний төвд нийт 208 үйлчлүүлэгчдээс байнгын асаргаатай 54 хүн, төрөлхийн хэлгүй, дүлий 2 хүн төрөлхийн оюуны хомсдолтой 18 хүн, төрөл бүрийн саажилттай 15 хүн, тэргэнцэртэй 44 хүн, харааны хөгжлийн бэрхшээлтэй 16 хүн, давхардсан тоогоор сэтгэцийн эмгэгтэй 153 хүн асруулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд асрамжийн төвөөр үйлчлүүлэгчдийн тэтгэврийн 30.0 хувийн орлогын 195,081.6 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 515,728.9 мянган төгрөгийн орлого төвлөрч 2.6 дахин давж биелсэн байна.

Бусад асуудал

Ахмад настны үндэсний төв нь тайлант хугацаанд 44 зорилтын 214 арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэл 87.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,174,224,317.44	1,226,258,306.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,000.00
31210	Төгрөг	-	10,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	10,000.00
33	АВЛАГА	35,165,594.17	332,172,080.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,445,780.07	1,445,780.07
33300	Татаас, санхүүжилтийн авлага	33,719,814.10	320,636,300.00
33500	Бусад авлага	-	10,090,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	10,090,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,139,058,723.27	894,076,226.08
35100	Түүхий эд материал	79,788,188.63	51,946,396.78
35130	Эм боох материал	79,788,188.63	51,946,396.78
35400	Хангамжийн материал	1,013,420,534.64	842,129,829.30
35410	Бичиг хэргийн материал	1,127,000.00	667,500.00
35420	Аж ахуйн материал	208,672,898.00	198,097,054.00
35440	Түлш, шатах тослох материал	23,103,889.64	25,227,024.40
35460	Хүнсний материал	468,814,847.60	302,533,530.90
35470	Бусад хангамжийн материал	311,701,899.40	315,604,720.00
35600	Мал амьтад	45,850,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,395,740,289.77	10,099,408,133.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,395,740,289.77	10,099,408,133.74
39200	Биет хөрөнгө	9,992,798,909.81	9,698,226,753.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,921,405,448.08	10,921,405,448.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,650,799,564.70)	(1,865,680,678.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	311,418,764.00	311,418,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(248,479,180.72)	(266,175,014.04)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,384,242,308.44	1,382,999,316.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(778,356,093.50)	(861,249,500.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	186,186,879.99	226,911,579.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(132,819,651.78)	(151,403,161.16)
39300	Биет бус хөрөнгө	402,941,379.96	401,181,379.92
39301	Програм хангамж	9,570,000.00	9,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,530,000.04)	(4,290,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	395,901,380.00	395,901,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	11,569,964,607.21	11,325,666,439.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,569,964,607.21	11,325,666,439.89
51	Засгийн газрын хувь оролцоо	11,569,964,607.21	11,325,666,439.89
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,264,908,232.00	1,264,908,232.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,264,908,232.00	1,264,908,232.00
51200	Хуримтлагдсан үр дүн	9,500,130,536.17	9,255,832,368.85
51210	Өмнөх үеийн үр дүн	8,484,001,885.37	9,500,130,536.17
51220	Тайлант үеийн үр дүн	1,016,128,650.80	(244,298,167.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	804,925,839.04	804,925,839.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	11,569,964,607.21	11,325,666,439.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,985,456,835.94	6,800,778,177.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	952,768,435.94	6,800,778,177.01
120	Нийтлэг татварын бус орлого	952,768,435.94	626,201,373.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	386,694,565.94	482,008,160.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	385,889,565.94	482,008,160.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	805,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	495,272,000.00	76,791,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	70,801,870.00	67,401,813.00
122	Тусламжийн орлого	-	6,174,576,804.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,174,576,804.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,173,572,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	6,173,572,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,003,904.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,003,904.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,032,688,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,000,020,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,000,020,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,668,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,668,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,968,310,218.42	7,045,076,344.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,968,310,218.42	7,045,076,344.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,866,864,281.55	6,984,143,809.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,258,888,686.90	3,796,461,910.21
210101	Үндсэн цалин	1,552,137,567.49	1,800,131,435.39
210102	Нэмэгдэл	1,454,137,304.72	1,567,650,418.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,552,439.20	285,825,362.71
210104	Урамшуулал	197,061,375.49	142,854,693.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	410,054,937.51	448,551,000.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	285,486,953.28	305,000,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	32,729,062.57	35,883,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	17,873,685.80	18,006,900.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	15,397,103.15	17,927,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	58,568,132.71	71,732,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	406,996,582.79	474,710,748.91
210301	Гэрэл, цахилгаан	128,895,942.79	142,259,618.47
210302	Түлш, халаалт	258,361,640.00	313,921,130.44
210303	Цэвэр, бохир ус	19,739,000.00	18,530,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	124,147,871.22	167,012,630.66
210401	Бичиг хэрэг	5,171,500.00	6,592,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,446,450.00	16,126,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,584,187.22	3,433,318.33
210404	Ном, хэвлэл	183,980.00	-

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,095,400.00	5,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,093,669.00	108,166,524.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,234,210.00	-
210408	Бараа материал акталсны зардал	14,338,475.00	27,593,458.33
2105	Нормативт зардал	1,100,743,059.71	1,486,716,440.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,498,041.57	132,980,175.12
210502	Хоол, хүнс	780,645,771.14	1,085,480,245.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	191,599,247.00	268,256,019.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	188,385,525.00	63,381,051.00
210604	Урсгал засвар	188,385,525.00	63,381,051.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,835,165.84	50,308,559.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,186,526.84	41,959,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	4,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,000.00	676,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	467,920.00	572,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,099,000.00	366,000.00
210807	Газрын төлбөр	3,532,719.00	1,657,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,812,452.58	497,001,469.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,720,000.00	95,148,913.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	237,092,452.58	401,852,556.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,445,936.87	60,932,535.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	42,502,835.30
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	42,502,835.30
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	42,502,835.30
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	41,416,537.19
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	1,003,904.00
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	82,394.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,757,100.00	18,429,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,979,600.00	10,425,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,437,500.00	8,004,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,340,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,688,836.87	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,688,836.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,017,146,617.52	(244,298,167.32)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,017,966.72	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,017,966.72	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,017,966.72)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,016,128,650.80	(244,298,167.32)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,419,382,965.94	6,690,304,778.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	386,694,565.94	6,690,304,778.11
120	Нийтлэг татварын бус орлого	386,694,565.94	515,727,974.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	386,694,565.94	515,727,974.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	385,889,565.94	515,727,974.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	805,000.00	-
122	Тусламжийн орлого	-	6,174,576,804.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,174,576,804.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,173,572,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	6,173,572,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,003,904.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,003,904.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,032,688,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,000,020,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,000,020,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,668,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,668,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,341,406,965.94	6,661,565,778.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,341,406,965.94	6,661,565,778.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,206,241,214.97	6,279,996,942.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,260,334,466.97	3,796,461,910.21
210101	Үндсэн цалин	1,539,138,509.15	1,800,131,435.39
210102	Нэмэгдэл	1,467,136,363.06	1,567,650,418.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,135,639.20	285,825,362.71
210104	Урамшуулал	192,923,955.56	142,854,693.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	410,054,937.51	448,551,000.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	279,216,600.00	305,000,900.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	32,729,062.57	35,883,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	17,873,685.80	18,006,900.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	15,397,103.15	17,927,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	64,838,485.99	71,732,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	418,469,602.43	477,913,413.67
210301	Гэрэл, цахилгаан	128,895,942.79	142,259,618.47
210302	Түлш, халаалт	269,834,659.64	315,001,795.20
210303	Цэвэр, бохир ус	19,739,000.00	20,652,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	93,044,087.22	59,586,018.33
210401	Бичиг хэрэг	2,784,100.00	2,169,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,540,000.00	10,547,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,584,187.22	3,433,318.33
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,095,400.00	6,170,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,040,400.00	37,265,000.00
2105	Нормативт зардал	1,668,544,020.00	1,308,702,611.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	172,103,120.00	95,962,711.60

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	1,137,409,400.00	926,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	359,031,500.00	286,739,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,243,710.00	14,162,150.00
210604	Урсгал засвар	22,243,710.00	14,162,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,550,390.84	174,619,839.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	322,901,751.84	166,270,280.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	4,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	549,000.00	676,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	467,920.00	572,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,099,000.00	366,000.00
210807	Газрын төлбөр	3,532,719.00	1,657,719.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,165,750.97	381,568,835.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	363,139,135.30
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	363,139,135.30
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	363,139,135.30
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	41,416,537.19
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	1,003,904.00
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	82,394.11
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	320,636,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,757,100.00	18,429,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,979,600.00	10,425,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,437,500.00	8,004,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,340,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,408,650.97	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,408,650.97	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	77,976,000.00	28,739,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	77,976,000.00	28,729,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,976,000.00	28,729,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	77,976,000.00	28,729,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,976,000.00	28,729,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(77,976,000.00)	(28,729,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	10,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,484,001,885.37	10,553,835,956.41
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	8,484,001,885.37	10,553,835,956.41
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,016,128,650.80	1,016,128,650.80
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,500,130,536.17	11,569,964,607.21
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,500,130,536.17	11,569,964,607.21
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(244,298,167.32)	(244,298,167.32)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,264,908,232.00	804,925,839.04	9,255,832,368.85	11,325,666,439.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	12. Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,700,145,800.00	6,647,884,336.92	52,261,463.08	99.2
12	Татварын бус орлого	6,700,145,800.00	6,647,884,336.92	52,261,463.08	99.2
120	Нийтлэг татварын бус орлого	195,081,600.00	515,727,974.11	(320,646,374.11)	264.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	195,081,600.00	515,727,974.11	(320,646,374.11)	264.4
122	Тусламжийн орлого	6,505,064,200.00	6,132,156,362.81	372,907,837.19	94.3
122005	Төсвөөс санхүүжих	6,505,064,200.00	6,132,156,362.81	372,907,837.19	94.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,700,145,800.00	6,327,155,642.81	372,990,157.19	94.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,700,145,800.00	6,327,155,642.81	372,990,157.19	94.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,681,716,100.00	6,308,725,942.81	372,990,157.19	94.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,844,652,000.00	3,796,461,910.21	48,190,089.79	98.7
210101	Үндсэн цалин	1,908,601,500.00	1,800,131,435.39	108,470,064.61	94.3
210102	Нэмэгдэл	1,394,477,000.00	1,567,650,418.91	(173,173,418.91)	112.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	358,870,300.00	285,825,362.71	73,044,937.29	79.6
210104	Урамшуулал	182,703,200.00	142,854,693.20	39,848,506.80	78.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	448,551,000.00	448,551,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	305,000,900.00	305,000,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	35,883,100.00	35,883,100.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,006,900.00	18,006,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	17,927,500.00	17,927,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	71,732,600.00	71,732,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	477,913,700.00	477,913,413.67	286.33	100.0
210301	Гэрэл, цахилгаан	176,781,000.00	142,259,618.47	34,521,381.53	80.5
210302	Түлш, халаалт	280,480,000.00	315,001,795.20	(34,521,795.20)	112.3
210303	Цэвэр, бохир ус	20,652,700.00	20,652,000.00	700.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	72,783,800.00	59,586,018.33	13,197,781.67	81.9
210401	Бичиг хэрэг	2,707,100.00	2,169,900.00	537,200.00	80.2
210402	Тээвэр, шатахуун	11,772,000.00	10,547,300.00	1,224,700.00	89.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,874,800.00	3,433,318.33	2,441,481.67	58.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,541,900.00	6,170,500.00	1,371,400.00	81.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,888,000.00	37,265,000.00	7,623,000.00	83.0
2105	Нормативт зардал	1,617,164,300.00	1,308,702,611.60	308,461,688.40	80.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,529,000.00	95,962,711.60	40,566,288.40	70.3
210502	Хоол, хүнс	1,175,312,800.00	926,000,000.00	249,312,800.00	78.8

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	305,322,500.00	286,739,900.00	18,582,600.00	93.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,162,200.00	14,162,150.00	50.00	100.0
210604	Урсгал засвар	14,162,200.00	14,162,150.00	50.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	206,489,100.00	203,348,839.00	3,140,261.00	98.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,081,600.00	194,999,280.00	82,320.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,927,400.00	4,900,000.00	27,400.00	99.4
210803	Даатгалын үйлчилгээ	825,700.00	676,920.00	148,780.00	82.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	806,800.00	572,920.00	233,880.00	71.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	224,800.00	176,000.00	48,800.00	78.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	985,300.00	366,000.00	619,300.00	37.1
210807	Газрын төлбөр	3,637,500.00	1,657,719.00	1,979,781.00	45.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,429,700.00	18,429,700.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,429,700.00	18,429,700.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,425,700.00	10,425,700.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,004,000.00	8,004,000.00	-	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00	(10,000.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	225	225	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	112	112	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	70	70	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	110	110	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	4	4	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	49	49	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	57	57	-	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	1,003,904.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,003,904.00
122	Тусламжийн орлого	-	1,003,904.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,003,904.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,003,904.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,003,904.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллагын зорилго нь үйлчлүүлэгчдийн эрхийг хүндлэн дээдэлж, сувилахуйн тусламж, үйлчилгээ, эмчилгээ үзүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нас, биеийн онцлогт тохирсон хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах, хөгжүүлэх цаашид бие даан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Ахмад настны үндэсний төв нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Үйлчлүүлэгчдийг эрүүл аюулгүй таатай орчинд амьдруулах;
- Үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хувцас, эм тариа, ахуйн хэрэгслээр хангах;
- Үйлчлүүлэгч бүрд нөхцөл байдлын үнэлгээ хийж нас, биеийн онцлог тохирсон хөгжилд, хамгааллын шаардлагатай бүхий л үйлчилгээг үзүүлэх;
- Үйлчлүүлэгч бүрд биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ асаргаа, сувилахуйн тусламж үзүүлэх;

Ахмад настны үндэсний төв нь тайлант хугацаанд 4 зорилтын 61 арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэл 80.4 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ахмад настны үндэсний төв нь асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг зориулалтын байранд байнга байршуулан хоол хүнс, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх зэрэг амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах ажлыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Ахмад настны үндэсний төв нь Ахмад настны тухай, Ахмад настны нийгмийн халамжийн тухай, Хувь хүний нууцын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон.

Тус төвийн даргын 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Б/41 дүгээр тушаалаар баталсан Дотоод хяналт, шалгалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Төвийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Б/154 дүгээр тушаалаар Дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан мэргэжилтнийг, 2023 оны 11 дүгээр сарын 29 -ний өдрийн А/ 18 тоот тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилсон байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2025 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг Төвийн даргын даргаар мөрдүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажилласан байна.

Тайлант онд Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус төвийн бүтэц орон тоо, 2023-2024 оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, худалдан авалт, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, нийт 2,353,413.5 мянган төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 1 акт, 3 зөвлөмж хүргүүлсэн байна. Шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг дээд газарт хүргүүлсэн байна.

Төвийн 2025 оны үйл ажиллагаанд Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ахмад настны үндэсний төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ахмад настны үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/124 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч, санхүүжилт, дотоод хяналт, үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан шинээр батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 244,215.8 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10.0	10.0
Авлага	35,165.6	332,254.5	297,088.9
Бараа материал	1,139,058.7	894,076.2	(244,982.5)
Үндсэн хөрөнгө	10,395,740.3	10,099,408.1	(296,332.2)
Нийт хөрөнгө	11,569,964.6	11,325,748.8	(244,215.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,569,964.6	11,325,748.8	(244,215.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,569,964.6	11,325,748.8	(244,215.8)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 10.0 мянган төгрөгөөр өссөн нь ХААН банк дахь асруулагчдын тэтгэврийн орлогын данс 10.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсантай холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 297,088.9 мянган төгрөгөөр өссөн нь асруулагчдын тэтгэврийн орлогын дансны үлдэгдэл 320,718.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн, малчны дутагдуулсан малын үнийг төлбөр болгосноос үүссэн 10,090.0 мянган төгрөгийг тус тус авлагаар бүртгэж, өмнөх оны төсөвт төвлөрүүлсэн 33,719.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, НДШ-ийн 1,445.8 мянган төгрөгийн авлагыг үлдэгдэлтэй байгаа зэрэг нь голлон нөлөөлжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 244,982.5 мянган төгрөгөөр буурсан нь 1,827,608.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, 10

байгууллагаас 50,181.8 мянган төгрөгийн, 38 хувь хүнээс 17,219.9 мянган төгрөгийн эм, хүнсний болон аж ахуйн материалыг хандиваар олгосныг тус тус орлогод авч, үйл ажиллагаанд 2,105,228.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 34,763.4 мянган төгрөгийн мал амьтад, аж ахуйн материалыг акталж данснаас хасалт хийснээс шалтгаалжээ.

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 296,332.2 мянган төгрөгөөр буурсан бөгөөд тайлант хугацаанд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
 - Нийт иргэн, аж ахуйн нэгжээс нийт 76,791.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 28,729.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан.
 - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 2025 оны 599 дүгээр тогтоолоор 66,038.7 мянган төгрөгийн 46 нэр төрлийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг данснаас хассан, тайлант хугацаанд 401,852.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, зардалд бүртгэсэн зэрэг нь нөлөөлжээ.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 244,215.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад тус төв нь 900.0 мянган төгрөгийн санхүүгийн “Acolaus” программ, хангамжийг 2016 оноос ашиглаж байгаа ба дэлгэрэнгүй судалгааг маягтаар баталгаажуулж баримтжуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,555,857.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 390,163.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 6,946,021.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 295,606.3 мянган төгрөгөөр бууруулж, 264,414.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 6,914,829.4 мянган төгрөгөөр баталжээ. Үүнд: Дотоод албан томилолтын зардлыг 41.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 1,271.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 31,857.9 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 36,500.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 45,437.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 180,497.3 мянган төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 91,907.2 мянган төгрөгөөр, цалин НДШ-ийн зардлыг 172,506.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн тодотголоор үндсэн үйл ажиллагааны орлогыг 195,081.6 мянган төгрөг, санхүүжилтийн эх үүсвэрийг 19,602.0 мянган төгрөг, нийт 214,683.6 мянган төгрөгөөр бууруулж, нийт 6,700,145.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,505,064.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 195,081.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,173,572.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 515,727.9 мянган төгрөгийг орлого төвлөрүүлж, 6,637,155.6 мянган төгрөгийг зарцуулж, 363,139.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,327,155.6 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 13,197.8 мянган, нормативт зардлыг 308,461.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 3,140.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс 320,718.7 мянган төгрөг үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 42,420.4 мянган төгрөг, нийт 363,149.1 мянган төгрөг төсөвт татан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902-80101 үндсэн үйл ажиллагааны зардал	6,486,634.5	6,113,726.6	372,907.9	94.3
2	71902-80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	18,429.7	18,429.7	-	100.0
3	71902-83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	195,081.6	194,999.3	82.3	99.9
	Дүн	6,700,145.8	6,327,155.6	372,990.2	94.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/100 тоот тушаалаар 123 орон тоотой ажиллахаар дээд хязгаарыг тогтоосныг Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/195 тоот тушаалаар 9 хувиар бууруулж 112 орон тоотой байхаар шинэчлэн тогтоосон ба гүйцэтгэлээр удирдах-1, гүйцэтгэх - 41, үйлчилгээний 70, нийт 112 орон тоогоор ажиллаж 3,796,461.9 мянган төгрөгийн зардал гаргасан байна.
- Байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын А/11 дүгээр тушаалаар баталсан хоолны хөнгөлөлтийг 10.0 мянган төгрөгөөр олгохоор тогтоосон ба хоолны зардалд 358,870.3 мянган төгрөгийг төлөвлөж 285,825.4 мянган төгрөгийг олгож, батлагдсан төсвийг 73,044.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь тайлант онд ажилчдын тоо буурснаас шалтгаалсан;
- Гадаад томилот, арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд зардал гараагүй.
- Тайланд онд сургалт арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, тайлант онд зардал гараагүй.
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй;
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй;

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Санхүүжилтийн эх үүсвэр 1,003.9 мянган төгрөг орж ирснийг зарцуулаагүй буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Ахмад настны үндэсний төв нь тайлант онд 1,718,182.5 мянган төгрөгийн 4 ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 261,900.6 мянган төгрөгийн 5 ажлыг харьцуулалтын аргаар, 11,772.0 мянган төгрөгийн 1 ажил, нийт 10 төрлийн бараа, үйлчилгээг 1,991,855.1 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж, байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 тоот тушаалаар баталгаажуулжээ.

Гүйцэтгэлээр www.tender.gov.mn цахим системээр 11,772.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 барааг, шууд худалдан авалтаар, 261,900.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 5 бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 1,718,182.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер

шалгаруулалтаар, нийт 1,991,855.1 мянган төгрөгийн 10 бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан 10 гүйцэтгэгчтэй 1,850,714.4 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 1,435,998.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Тайлант оны 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нүүрс нийлүүлэх тендерт шалгарсан “Хазаарбат “ХХК-тай нэмэлт гэрээг 4,393.8 мянган төгрөгөөр байгуулан бараа үйлчилгээг худалдан авч, төлбөрийг санхүүжүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, шилэн данс, үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер С.Сожидмаа, компанийн захирал С.Тунгалаг, анхан шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал, аудитын менежер А.Цогбаяр, Газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19 -ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 5,968,330.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 59,683.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 166 мэдээлэл байршуулахаас 161 мэдээллийг хугацаандаа байршуулж, 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, зардлын данснуудад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар нийт 197,810.9 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснийг арилгасан байна. Тухайлбал:

- Шалгагдагч байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөнд хяналтын түүвэрчилсэн тооллого гүйцэтгэхэд эд хариуцагч бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, хөрөнгийг кодолж бүртгээгүй;
- Нийт 8 төрлийн 6,795.0 мянган төгрөгийн шинээр ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх гарт олгосон дүнг мөнгөн гүйлгээний журналын дүнтэй тулгахад 36,218.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалин хөлсний зардалд бүртгэсэн;

- Ажилтанд шөнийн цагийн нэмэгдлийг 259,060.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсноос шалтгаалан ХХОАТ-т 63,599.8 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн;
- Хүнсний материалын үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхэд 25,599.8 мянган төгрөгийн материал биетээр байгаагүй;

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 901.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 52,220.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажиллажээ.

Хүснэгт 4 :Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	901.2	1	901.2	100.0
Зөвлөмж	2	52,220.0	2	52,220.0	100.0
Нийт дүн	3	53,121.2	3	53,121.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын шинэчлэн баталсан заавар журмуудад нийцүүлэн шинэчлэн баталсан байдал, үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлсэн эсэх, шилэн дансны хуулийн хэрэгжилт, асруулагчдын хоолны тооцоо, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,156,435.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,156,435.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Ажиллагсдын цалин хөлснөөс суутгасан НДШ-ийг Нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад 20 ажилтнаас 10,880.9 мянган төгрөгийг илүү, 6 ажилтнаас 5,216.9 мянган төгрөгийг дутуу суутгасан;
- Үр дүнгийн тайланд тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнтэй тулган шалгахад НДШ-ийн тайланд 20,189.2 мянган төгрөгийг илүү тайлагнасан;
- Санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 2024 оны үлдэгдэл 34.1 мянган төгрөг, 2025 оны жилийн эцсийн үлдэгдэл 10.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй;
- Санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 2024 оны үлдэгдэл 34.1 мянган төгрөг, 2025 оны жилийн эцсийн үлдэгдэл 10.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй;
- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын А/03- аар тушаалаар баталсан маягт, аргачлалын дагуу иж бүрэн бэлтгээгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулж тайлагнаагүйгээс 363,139.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд тайлагнасан бараа материалын оны эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн дүнгээс хүнсний материал 445,710,9 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 288,598,0 мянган төгрөгөөр, мал амьтад 22,746.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан;

Эдгээр алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 9 дүгээр зүйлийн 9.6, 14 дүгээр зүйлийн 14.4.2, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 26.3 гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа” УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 249,888.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 39,673.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 170,034.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 40,180.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 249,888.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 190,194.8 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Байгууллагын дотоод журамд заасан хоолны хөнгөлөлтийг ээлжийн ажилтнуудад асруулагчдын хоолны ор хоногийн зардалтай давхардуулан олгосны шалтгаалан 42 хүнд нийт 35,280.0 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;", 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;","Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа насанд хүрэгсдийн хоногт хэрэглэх хоолны норм , илчлэгийн хэмжээ , зардлын норматив"-ыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн ажилчдад илүү олгосон 35,280.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Худалдан авалтын гэрээний дүнгээс нийт 1 харилцагч байгууллагад 4,393.8 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны " Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолын "шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг" гэж заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний батлагдсан үнээс 4,393.8 мянган төгрөгийг илүү олгосон зөрчлийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант онд малчны дутагдуулсан 10,090.0 мянган төгрөгийн балансын үнэтэй 4 бод, 54 бог, нийт 58 малыг зах зээлийн үнийг үндэслэл болгохгүйгээр дансны үнээр авлага болгон бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд дутагдуулсан малын үнийг зах зээлийн үнээр тооцоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Асруулагчдын хоолны зардлыг батлагдсан норм, нормативаас 122,799.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байхад тооцоог бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа насанд хүрэгсдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Асруулагчдын хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцоогүй, тооцоог бодож баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 20 удаагийн гүйлгээгээр 35,699.3 мянган төгрөгийн шатахууныг шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны " Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох

тухай" тогтоолын "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Ахмад настны үндэсний төв нь 1 харилцагчийн 1,445.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу шинэчлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", "УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдааны 7-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтоосон практик юм" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаж, өөрчлөлт, шинэчлэлт хийх.

2. Худалдан авалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн баримтын дүнгээс 1 байгууллагад 4,320.0 мянган төгрөгөөр илүү, 29 иргэн байгууллагын дүнг 35,860.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл

хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.б-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримтыг сар бүр хянаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад 20 ажилтнаас 10,880.9 мянган төгрөгийг илүү, 6 ажилтнаас 5,216.9 мянган төгрөгийг дутуу суутгасан.	1	16,007.9	-	-	1	16,007.9	1	16,007.9	-	-	-	-
2	Үр дүнгийн тайланд тайлагнасан цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг НДШ-ийн тайлангийн дүнгээс 20,189.2 мянган төгрөгийг илүү тайлагнасан.	1	20,189.2	1	-	1	20,189.2	1	20,189.2	-	-	-	-
3	Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад өмнөх оны үлдэгдэл 34.1 мянган төгрөг, тайлант оны жилийн эцсийн үлдэгдэл 10.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй.	1	44.1	1	44.1	-	-	1	44.1	-	-	-	-
4	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын А/03- аар тушаалаар баталсан маягт, аргачлалын дагуу иж бүрэн бэлтгээгүй.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

5	Төсвийн гүйцэтгэлийн тайланг 363,139.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	363,139.1	-	-	1	363,139.1	1	363,139.1	-	-	-	-
6	Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн үлдэгдлээс хүнсний материал 445,710.9 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 288,598.0 мянган төгрөгөөр, мал амьтад 22,746.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	757,055.1	-	-	1	757,055.1	1	757,055.1	-	-	-	-
Дүн		6	1,156,435.4	2	44.1	5	1,156,391.3	6	1,156,435.4	-	-	-	-

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал			
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант онд малчны дутагдуулсан 10,090.0 мянган төгрөгийн балансын үнэтэй нийт 58 малыг зах зээлийн үнийг үндэслэл болгохгүйгээр дансны үнээр авлага болгон бүртгэсэн.	1	10,090.0	-	-	1	10,090.0					-	-	-	-
2	Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу шинэчлээгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
3	Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь төлбөрийн цахим системд бүртгэсэн баримтын дүнгээс 4,320.0 мянган төгрөгөөр илүү, 35,860.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн.	1	40,180.0	-	-	-	-	1	40,180.0	-	-	-	-	-	-
4	Асруулагчдын ор хоногийн тоонд ээлжийн ажилчдын тоог нэмж тооцож хоолны зардлыг ээлжийн ажилчдын хоолны мөнгийг давхардуулан олгосон.	1	35,280.0	1	35,280.0	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Асруулагчдын хоолны зардлыг батлагдсан норм,	1	122,799.3	-	-	1	122,799.3	-	-	-	-	-	-	-	-

Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	нормативаас 122,799.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.												
6	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 35,699.3 мянган төгрөгийн шатахууныг шууд худалдан авалт хийсэн.	1	35,699.3	-	-	1	35,699.3	-	-	-	-	-	-
7	Худалдан авалтын гэрээний дүнгээс нийт 2 харилцагч байгууллагад 4,393.8 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн.	1	4,393.8	1	4,393.8			-	-	-	-	-	-
8	Ахмад настны үндэсний төв нь 2 харилцагчийн 11,445.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй .	1	1,445.8	-	-	1	1,445.8	-	-	-	-	-	-
	Дүн	8	249,888.1	2	39,673.8	4	170,034.3	2	40,180.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 166 мэдээлэл байршуулахаас 161 мэдээллийг хугацаандаа байршуулж, 5 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	Нийт дүн	1	-	-	-	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 106/А0150169
САГ-2026/17/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дотоод журамд заасан хоолны хөнгөлөлтийг асруулагчдын хоолны ор хоногийн зардалтай давхардуулан ээлжийн ажилтан 42 хүнд нийт 35,280,000.00 /Гучин таван сая хоёр зуун наян мянган/ төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.2.2-т "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/130 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6-р дугаар хүснэгтээр баталсан Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа насанд хүрэгсдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ахмад настны үндэсний төв нь ээлжийн ажилчдын хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон 35,280,000.00 /Гучин таван сая хоёр зуун наян мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-63.Docx

1526200064



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 107/АО150169
САГ-2026/14/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авалтын гэрээний дүнгээс 1 харилцагч байгууллагад 4,393,795.20 /Дөрвөн сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун ерэн таван мянга хорин мөнгө/ төгрөгийг илүү шилжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ахмад настны үндэсний төв нь гэрээнд тусгагдсан дүнгээс илүү шилжүүлсэн 4,393,795.20 /Дөрвөн сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун ерэн таван мянга хорин мөнгө/ буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

513/АО150169

САГ-2026/17/НА-СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахмад настны үндэсний төв нь 1 харилцагчийн 1,445,780.07 /Нэг сая дөрвөн зуун дөчин таван мянга долоон зуун наян төгрөг долоон мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 512/А0150169
САГ-2026/17/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд малчны дутагдуулсан 10,090,000.00 /Арван сая ерэн мянган/ төгрөгийн балансын үнэтэй 4 бод, 54 бог, нийт 58 малыг зах зээлийн үнийг үндэслэл болгохгүйгээр дансны үнээр авлага болгон бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "Өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Малчны дутагдуулсан малыг зах зээлийн үнээр тогтоогоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

С.ТУНГАЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 54/А0150169
САГ-2026/17/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйлчлүүлэгчдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 122,799,257.30 /Нэг зуун хорин хоёр сая долоон зуун ерэн есөн мянга хоёр зуун тавин долоон мянган төгрөг гучин мөнгө/ төгрөгөөр дутуу зарцуулсан байхад тооцоог бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Асруулагчдын хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцоогүй, тооцоог бодож баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-97.Docx

1526181099



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 510/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/17/НХ-СТА-ТЦУЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 20 удаагийн гүйлгээгээр нийт 35,699,300.00 /Гучин таван сая зургаан зуун ерэн есөн мянга гурван зуу/ төгрөгийн шатахууныг шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан" Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолын "шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг" гэж заасантай тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй шатахууныг шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга /Л.Эрдэнэхүү/, ахлах нягтлан бодогч /У.Амарсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125.SAG-97.Docx

1526181101